



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ГИШҮҮН, БОЛОВСРОЛЫН  
САЙД П.НАРАНБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025.08.28 № 35

Боловсролтой монгол хүний  
баталгааг хангах талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан тус улсын иргэний боловсролын талаар баталгаатай эдэлбэл зохих эрхийн талаар “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно” гэж; 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан билээ. Үндсэн хуульд заасанчлан “сурч боловсрох”, “боловсролыг төлбөргүй олгох”, “төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулах” гэсэн асуудалтай холбоотой иргэний эрхийн хэрэгжилт ямар түвшинд байна хэмээн үзэж байна? Эдгээр асуудлын хүрээн дэх төрийн бодлого, хэрэгжилтийн үр дүн, иргэний сурч боловсрох эрхийн зөрчлийг арилгах, хэрэгжилтийг хангах зорилгоор богино болон дунд хугацаанд төлөвлөж буй зорилт, арга хэмжээний талаарх мэдээлэл;

2. Орчин үеийн шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжлийн эрин үе дэх нийгмийн болон бие хүний хөгжил, түүний дотор монгол хүний эрдэм боловсролын бодит эрэлт хэрэгцээг хангахад Монгол Улсын боловсролын салбарын эрх зүйн орчин хэр нийцэж байна? Хүүхэд, залуучуудад хүртээмжтэй, чанартай боловсрол олгохын тулд, мөн хөтөлбөрийн агуулга, хэлбэр, арга зүйг шинэчлэн өөрчлөхийн тулд салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ямар бодлого, стратегийн чиглэл баримтлан ажиллаж байна вэ?

3. Хүний хөгжлийг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг тэргүүлэх салбар бол боловсролын салбар мөн билээ. Иймд дотоодын нийт бүтээгдэхүүнд энэхүү тэргүүлэх салбарт төрийн зүгээс хандаж буй хандлагын гол шалгуур нь улсын нэгдсэн төсвөөс зарцуулж буй зардал, хөрөнгө оруулалтын эзлэх хувь хэмжээ байх учиртай юм. Сүүлийн таван жилийн дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын салбарын төсвийн эзлэх хувь 5 хувиас хэтрэхгүй байна. Үүнтэй холбоотойгоор боловсролын үйлчилгээг хүүхэд бүрд жигд хүртээмжтэй, чанартай олгох үйлсэд тус салбарын өнөөгийн төсөв, хөрөнгө оруулалт нь санхүүжилтийн хувьд баталгаа болж чадаж байна уу? Энэ талаар сүүлийн 10 жилд улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарын хөгжилд зориулан зарцуулсан зарцуулалтын хэмжээ, дотоодын нийт бүтээгдэхүүнд болон улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогод эзлэх хувь, бүтэц, зориулалт, үр нөлөө болон үр дүнгийн талаар шинжилгээ хийсэн талаарх мэдээлэл; Боловсролын яамнаас цаашид эрдэм боловсролтой монгол хүнийг

2025000061

төлөвшүүлэхэд чиглэгдсэн төсөв, санхүүгийн баталгааг бодитойгоор бүрдүүлэхийн тулд ямар зарчим, бодлого баримтлах вэ?

4.Багш нарын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг хангах чиглэлээр ойрын хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, арга хэмжээний талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a date. A long, thin black line is drawn across the signature and the stamp, extending from the bottom left towards the center.

С.ЭРДЭНЭБОЛД

2025000061